

БАТЛАВ.



СХОЭрхэлсэн дэд захирал Л.Баяр-Эрдэнэ

БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ, ХАРЬЯА НЭГЖИЙН ЗАХИРЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ, ХУВААРЬ

Зорилго: Бүрэлдэхүүн сургууль, харьяа нэгжийн захирлын 2021-2022 оны хичээлийн жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг тухайн бүрэлдэхүүн сургууль нэгжийн нийт профессор, багш, ажилтны хурлаар хэлэлцүүлж, үнэлж, дүгнэхэд оршино.

Хуралд оролцох төлөөлөгчид: ШУТИС-ийн дэд захирлууд, мэргэжилтнүүд дараах хуваарийн дагуу оролцоно.

Хугацаа: 2022 оны 05 дугаар сарын 31-наас 06 дугаар сарын 3-ны өдрүүдэд болно

Хурлын бэлтгэл:

1. Бүрэлдэхүүн сургуулийн захирлууд тайлангаа товч тодорхой, хүрсэн түвшинг хэмжигдэхүйц, ойлгомжтой хэлбэрээр Power Point дээр бэлтгэж, 25 минутад багтаан хамт олондоо танилцуулна. Тайлангийн ерөнхий агуулга:
 - Бүтэц, зохион байгуулалт, гарсан өөрчлөлт
 - 2021-2022 оны хичээлийн жилийн онцлох үйл явдал
 - Үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд (өмнөх жилүүдтэй харьцуулж график хэлбэрээр илэрхийлэх)
 - 2021-2022 оны хичээлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл нь зорилтот үр дүнд хүрсэн эсэх (зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх)
 - Төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцлийг тодорхой дурдах
 - Хөндлөнгийн байгууллагын хяналт, үнэлгээний талаарх мэдээлэл
 - Ирэх хичээлийн жилийн зорилт, арга хэмжээний санал
2. Хуралд оролцож буй ШУТИС-ийн дэд захирал хурлыг удирдан явуулна. Хурлын ирц тухайн сургуулийн нийт багш, ажилтны 80%-иас доошгүй байна. Хурлын ирцийг бүрдүүлэх асуудлыг тухайн бүрэлдэхүүн сургууль, нэгж хариуцна.
3. Профессор багш, ажилтан нарын хэлсэн үг, хүсэлт, санал, дүгнэлтийг тэмдэглэл хэлбэрээр хөтөлж, тэмдэглэл хөтөлсөн мэргэжилтэн, хурал удирдсан ШУТИС-ийн дэд захирал гарын үсгээ зурж баталгаажуулна.
4. Профессор багш нарт үг хэлэх, санал хүсэлт гаргах, тайланд үнэлэлт, дүгнэлт өгөх бололцоог ханган ажиллана.
5. Хурлын төгсгөлд Захирлын үйл ажиллагааны талаар профессор, багш ажилтны үнэлэлт, дүгнэлтийг **нууц санал** хураалтын маягаар авна.
6. Энэ ажлыг ШУТИС-ийн Захиргаанаас ажлын хэсэг болон сургуулийн төлөөлөл зохион байгуулна. Санал хураахын өмнө санал хураалтанд оролцогчдын тоог нарийвчлан гаргаж (01 тушаалын нэрсээр), зохион байгуулагчдаас баталгаажуулсан саналын хуудсыг тарааж өгнө. Санал хураалтын хайрцгийг бүрэлдэхүүн сургуулиуд бэлтгэнэ.
7. Нууц санал хураалтын хуудсыг томилогдсон захиргааны мэргэжилтнүүд, комисс тооцож, нэгтгэл хүснэгтэд оруулан дүнг хуралд оролцогчдод танилцуулна. Хурал удирдсан ШУТИС-ийн дэд захирал энэхүү үйл ажиллагаанд хяналт тавина.
$$\text{Үнэлгээний дундаж хувь} = \frac{\text{Нийт саналын хувь}}{\text{Санал өгсөн хүний тоо}}$$
8. Санал хураалтын хуудас болоод нэгтгэл хүснэгтийг уутанд хийж битүүмжлэн, тухайн сургуулийн тамга дарж, Захиргаа, хүний нөөцийн газарт ирүүлнэ.

НЭГТГЭЛ ХҮСНЭГТИЙН МАЯГТ

Тайлангийн хурлын огноо:

Сургуулийн нэр:

Санал өгсөн хүний тоо:

Ирцийн хувь:

| | <i>0-30% Удирдлага зохион байгуулалт хангалтгүй буюу үр дүнгүй ажилласан</i> | <i>31%-59% Удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай</i> | <i>60%-89% Тодорхой үр дүнд хүрч ажилласан буюу хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай</i> | <i>90%-100% Удирдлага зохион байгуулалт сайн, үр дүнг гарсан</i> |
|--|--|---|---|--|
| Санал өгсөн хүний тоо | - | - | - | - |
| Үнэлгээний дундаж хувь | - | | | |
| Цаашид анхаарч сайжруулах зүйлс | 1. 2. 3. 4. | | | |

САНАЛ ХУРААЛТЫН ХУУДАСНЫ МАЯГТ

| Үнэлгээний хувь | <i>(энд зөвхөн 1-100% хүртэлх тоог бичнэ.)</i> |
|--|--|
| Цаашид анхаарч сайжруулах зүйлс | <i>(энд зөвхөн 1-3 хүртэлх боломжит зорилт, арга хэмжээг бичнэ.)</i> 1. 2. 3. |

*Үнэлгээний хувь тооцох аргачлал:

- 0-30% - Удирдлага зохион байгуулалт хангалтгүй буюу үр дүнгүй ажилласан
- 31%-59% - Удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай
- 60%-89% - Тодорхой үр дүнд хүрч ажилласан буюу хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай
- 90%-100% - Удирдлага зохион байгуулалт сайн, үр дүнд хүрсэн

**Бүрэлдэхүүн сургууль, харьяа нэгжийн захирлын тайлангийн
хуралд оролцох хүмүүсийн нэрс**

| № | Бүрэлдэхүүн сургууль, нэгж | Хурал эхлэх цаг | ШУТИС-ийн дэд захирал | Оролцох хүмүүсийн нэрс | Уулзалт болох өрөө |
|---|----------------------------|-----------------|-----------------------|--------------------------------|--------------------|
| 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр | | | | | |
| 1 | БАС | 10:00 | Д.Мягмарсүрэн | Т.Энхцацрал Д.Одонтуяа | ТВ заал |
| 2 | БуХС | 10:00 | Д.Цолмонбаатар | Д.Бямбасүрэн Б.Санжидмаа | 5-411 |
| 3 | ГУУС | 10:00 | Ц.Баатархүү | Д.Гэрэлт-Од Б.Мөнгөнсар | Урлаг танхим |
| 4 | ГХС | 10:00 | Л.Баяр-Эрдэнэ | Ж.Арслан Ш.Доржсүрэн | НСан-604 |
| 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр | | | | | |
| 5 | ЭХС | 14:00 | Л.Баяр-Эрдэнэ | Ж.Арслан Б.Мөнгөнсар | НСан-604 |
| 6 | БАТС | 14:00 | Д.Цолмонбаатар | Д.Бямбасүрэн Б.Санжидмаа | 5-411 |
| 7 | ШУТИС-Коосэн | 14:00 | Н.Ганзориг | Г.Жавхлан А.Оюундэлгэрэх | 8-301 |
| 8 | ХШУС | 14:00 | Д.Мягмарсүрэн | Д.Батдорж Г.Ариунтөгс | Урлаг танхим |
| 9 | ЕБАС | 14:00 | Ц.Баатархүү | Б.Одгэрэл Д.Цэнгэлмаа | 4-300 |
| 2022 оны 06 дугаар сарын 02-ний өдөр | | | | | |
| 10 | ҮТС | 10:00 | Д.Мягмарсүрэн | Д.Бямбасүрэн А.Оюундэлгэрэх | НСан-604 |
| 11 | МХТС | 10:00 | Н.Ганзориг | Э.Халиун Г.Ганбилэг | 6-225 |
| 12 | МехТС | 10:00 | Ц.Баатархүү | Д.Орхон Д.Цэнгэлмаа | Хурлын танхим |
| 13 | ИАТС | 10:00 | Л.Баяр-Эрдэнэ | Х.Отгон-Эрдэнэ Н.Баярмаа | 8-606 |
| 2022 оны 06 дугаар сарын 3-ны өдөр | | | | | |
| 14 | ДаТС | 10:00 | Ж.Арслан | Д.Гэрэлт-Од Ш.Доржсүрэн | |